



I-VI/2021


Тархаасан: 2021 оны 7 дугаар сарын 09



1000 хүнд ногдох төрөлт 0.6 нэгжээр буурчээ.

Улсын хэмжээнд 2021 оны эхний хагас жилийн байдлаар 36 334 эх амаржиж, 36 601 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 1 257 (3.3%)-оор, төрсөн хүүхэд 1 268 (3.3%)-аар тус тус буурчээ.


Зураг 1. Төрөлт, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар



1000 хүнд ногдох төрөлт өмнөх оны мөн үеэс 0.6 нэгжээр буурсан байна.

1000 хүнд ногдох төрөлт Улаанбаатар хот болон Баян-Өлгий, Говьсүмбэр, Өмнөговь, Говь-Алтай, Орхон, Ховд, Увс, Сүхбаатар аймагт улсын дунджаас 0.2-2.0 нэгжээр дээгүүр, Дорнод аймагт ижил түвшинд, бусад аймагт 0.4-4.6 нэгжээр доогуур байна.

Зураг 2. Нас баралт, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар



Нас баралт 8 371 болж, өмнөх оны мөн үеэс 511 (6.5%)-ээр өсжээ. 1000 хүнд ногдох төрөлт 10.8, нас баралт 2.5, ердийн цэвэр өсөлт 8.3 байна.

1000 хүнд ногдох нас баралт өмнөх оны мөн үеэс 0.1 нэгжээр өсжээ.

1000 хүнд ногдох нас баралт Улаанбаатар хот болон Завхан, Хөвсгөл, Сүхбаатар аймагт улсын дунджаас 0.1-0.2 нэгжээр дээгүүр, харин бусад аймагт 0.1-0.7 нэгжээр доогуур байна.

1000 хүнд ногдох ердийн цэвэр өсөлт Улаанбаатар хот болон Баян-Өлгий, Говьсүмбэр, Өмнөговь, Ховд, Орхон, Говь-Алтай, Увс, Дорнод, Дархан-Уул, Сүхбаатар аймагт улсын дунджаас 0.1-2.7 нэгжээр дээгүүр, харин бусад аймагт 0.3-4.3 нэгжээр доогуур байна.

Хүснэгт 1. 1000 хүнд ногдох төрөлт, нас баралт, ердийн цэвэр өсөлт, бүс, аймаг, нийслэлээр, 2021 оны эхний хагас жилийн байдлаар

Аймаг, нийслэл	Төрөлт	Нас баралт	Ердийн цэвэр өсөлт
Дүн	10.8	2.5	8.3
Баруун бүс	11.5	2.2	9.3
Баян-Өлгий	12.8	1.8	11.0
Говь-Алтай	11.5	2.4	9.1
Завхан	10.1	2.7	7.4
Увс	11.0	2.3	8.7
Ховд	11.4	1.9	9.5
Хангайн бүс	9.8	2.3	7.5
Архангай	9.4	2.1	7.3
Баянхонгор	10.3	2.3	8.0
Булган	7.7	2.4	5.3
Орхон	11.5	2.2	9.3
Өвөрхангай	9.2	2.2	7.0
Хөвсгөл	9.6	2.6	7.0
Төвийн бүс	9.4	2.2	7.2
Говьсүмбэр	12.4	2.0	10.4
Дархан-Уул	10.4	2.0	8.4
Дорноговь	10.4	2.4	8.0
Дундговь	9.9	2.3	7.6
Өмнөговь	12.4	2.0	10.4
Сэлэнгэ	7.8	2.3	5.5
Төв	6.2	2.2	4.0
Зүүн бүс	10.7	2.4	8.3
Дорнод	10.8	2.2	8.6
Сүхбаатар	11.0	2.6	8.4
Хэнтий	10.2	2.3	7.9
Улаанбаатар	11.5	2.7	8.8

Тайлбар: Эрүүл мэндийн яамны төрөлт, нас баралтын мэдээнд үндэслэн тооцов.

Ойлголт, тодорхойлолт: Хүн амын ердийн цэвэр өсөлтийг төрөлт, нас баралтын зөрүүгээр тодорхойлно.

Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

Мэдээлэл авах холбоосууд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 10 дугаар сарын 15

Хүн ам, нийгмийн статистикийн газрын
дарга А.Амарбал
Утас : (976-51)-264805

Хүн ам, нийгмийн статистикийн газар
Хүн ам, орон сууцны тооллогын товчооны статистикч
Т.Ариунсайхан
Утас : (976-51)-267547

